

# УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2024.08.01-2024.08.30 ХҮРТЭЛ ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН МЭДЭЭ

Тайлангийн дугаар: Хяналт/2024/16

Хэвлэсэн огноо: 2024.09.02

## 1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын FM радио нэвтрүүлэх станцад MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг мөрдүүлэх зорилготой.

## 2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2024.08.01-2024.08.30	Улаанбаатар хотын СХД-ийн 34-р хороонд байрлах ХХЗХ-ны РДӨНХТ-ийн цамхагт байрших суурин хяналтын станц	/47°54'51.50"N 106°45'43.33"E/



Зураг 1. Хэмжилт хийсэн FMS-2020 суурин хяналтын станцын байршил

## 3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

FMS-2020 суурин хяналтын станц /RmcFX2dm02Mn/


## 4. Норматив бичиг баримт:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандарт

5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	М.Болдбат	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын ахлах инженер
2	Ж.Дөлгөөн	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер
3	М.Чагнаадорж	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер


6. Хэмжилт хийх үеийн зураг:




Зураг 2. Радио давтамжийн 88 МГц-108.0 МГц-ийн зурвасын хэмжилт

7. Хэмжилтийн дүн:


Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийдэг. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 33 хуулийн этгээдийн FM радиогийн нэвтрүүлэх станцуудад 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 30-ны өдрүүдэд суурин хяналтыг хийж гүйцэтгэлээ. Тус хяналтаар 5 FM радиогийн нэвтрүүлэх станцын давтамжийн хазайлтын максимум утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, эдгээрээс 2 FM радиогийн нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт стандарт хэмжээнээс хэтэрсэн, 1 FM радиогийн нэвтрүүлэгчийн хэрэглэх зурвасын өргөн стандарт хэмжээнээс хэтэрсэн, 2 FM радиогийн нэвтрүүлэх станц үйл ажиллагаагаа түр зогсоосон, 26 FM радиогийн нэвтрүүлэх станц хэвийн ажиллаж байгаа нь тогтоогдлоо.



Зураг 3. Давтамжийн хазайлтын максимум утгын хэмжилтийн үр дүн



Зураг 4. Зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын хэмжилтийн үр дүн



Зураг 5. Хэрэглэх зурвасын өргөний хэмжилтийн үр дүн

7.1 Үйл ажиллагаагаа түр зогсоосон:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7
2	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0

7.2 Стандартын шаардлагыг хангасан:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга  $\pm 75$  кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг хангаж үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22800192	88.3
2	СКОД ХХК	22800167	88.8
3	Сета тех ХХК	22800193	89.3
4	Эх болсон зургаан зүйл НҮТББ	22800186	89.7
5	Улаанбаатар телевиз ХХК	22800178	90.5
6	Монгол комикс ХХК	22800159	91.1

7	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
8	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
9	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	95.7
10	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
11	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд	22800071	97.5
12	Радиоком Монгол ХХК	22800025	98.1
13	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
14	Нью медиа ХХК	22800026	99.3
15	НС Холбоо ХХК	22800040	100.5
16	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22800044	100.9
17	Агрегатор ХХК	22800022	101.7
18	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
19	Бадруун ХХК	22800006	102.5
20	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22800044	103.1
21	Ви Өү Эм ХХК	22800052	104.0
22	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
23	Чугу ХХК	22800037	105.5
24	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22800044	106.0
25	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6
26	Билэг санаа ХХК	22800018	107.5

### 7.3 Стандартын шаардлагыг хангаагүй:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга  $\pm 75$  кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг хангаагүй хуулийн этгээдүүдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Шүхэр ТББ	22800117	95.1
2	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
3	Дижитал Радио ХХК	22800060	99.7
4	РФ ХХК	22800005	100.1
5	Медиа холдинг ХХК	22800009	103.6


MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц -ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг

хангаагүй хуулийн этгээдүүдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Авторадио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
2	Дижитал Радио ХХК	22800060	99.7

Мөн Авторадио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ-ийн 96.3 МГц FM радиогийн нэвтрүүлэгчийн хэрэглэх зурвасын өргөн стандарт хэмжээнээс хэтэрсэн байна.

#### 7.4 Ажиллаж буй дахин дамжуулах радио станцууд:



№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Чугу ХХК	22830003	76.9
2	Сета тех ХХК	22830002	77.3
3	Манай аялгуу эф эм ар ХХК	22830004	77.7
4	Эх элгэн нутаг ХХК	22830005	78.1
5	Бадруун ХХК	22830009	80.5
6	Эм Эс Жи Эм Эл ХХК	22830012	82.1
7	И Зэт Эф Эм ХХК	22830008	83.3
8	Радиоком Монгол ХХК	22830020	84.1

## 8. Дүгнэлт:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хэт богино долгионы FM радио нэвтрүүлэх станцуудын 78.7% нь MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.

Дээрх стандартын шаардлагыг хангахгүй байгаа шалтгаан нь тухайн радиогийн нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдийн тохиргооноос хамаарч байна. Иймд радиогийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы параметруудыг стандарт хэмжээнд байлгах, сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд буюу антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабель (фидер кабель, аудио кабель)-д тогтмол техникийн хяналт, үзлэг, үйлчилгээ хийж байх, студийн дууны холигч пультны түвшинг тогтмол хянаж, стандарт хэмжээнд тохируулж байхыг зөвлөж байна.